



“ДӨРВӨН-УУЛ” ХК-ИЙН
ЗАХИРАЛ П.БУЯНЖАРГАЛ
ТАНАА

“БЭСТ ФОРТУНА АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо,
“Монгол эмимпекс концерн” ХХК-ийн байр, 200 тоот
Утас: 324338, 89116465,
98056465, 98006465
И-мэйл: fortune_audit@yahoo.com

2019.03.20. № 53

танай _____-ны № _____-т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Аудиторын санал дүгнэлт

Бид “Дөрвөн-Уул” ХК-ийн 2018 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлангууд болон бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн байдал, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангуудыг бэлтгэхдээ СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол улсын Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт өгөх явдал юм. Бид АОУС-ын дагуу аудитаа хийж гүйцэтгэсэн болно. Ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд материаллаг алдаатай эсэх талаар ул үндэстэй баталгаажуулалт олж авахын тулд аудитыг төлөвлөж гүйцэтгэхийг эдгээр стандартууд биднээс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлангууд дахь дүнгүүд болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэдэг. Сонгосон горимууд нь аудиторын үнэлэмж, түүний дотор залилан эсвэл алдаанаас шалтгаалсан санхүүгийн тайлангууд дахь материаллаг алдаатай тайлагналын эрсдлийн үнэлгээнээс хамаардаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь тухайн байгууллагын дотоод хяналтын үр өгөөжийн талаар дүгнэлт гаргах зорилго тавилгүйгээр, тухайн нөхцөл байдалд тохиромжтой аудитын горимуудыг сонгохын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэж үнэн зөв толилуулахтай хамаатай дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн аудитаар тухайн хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон тооцооллын ул үндэслэлийг үнэлж, мөн санхүүгийн тайлангуудын нийт тодруулгыг үнэлдэг.

ЗАХИРАЛ



Ж. ОЮУНЦЭЦЭГ